



Б.МӨНХБААТАР

Хууль сахиулахын их сургууль
Шүүхийн нийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Нийгэмийн ажлын тэнхимийн
багш, ахлах дэслэгч

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЯЛТАН ГЭМТ, ХЭРЭГ-ЗӨРЧИЛ ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГЫГ ХАРГАЛЗАХ НЬ:

Сэтгэл судлалын шинжлэх ухаан нь амьд бие махбодийн мэдрэх чадвар, ертөнцийг тольдогч тусгал буюу уураг тархины үзэгдэл болох сэтгэц, ухамсарын мөн чанар, түүний хөгжил, гүйцэтгэх үүрэг зэргийг судалдаг. Нэгэнт орчныг тусгасан тусгалыг судалдаг тул эргээд орчны нөлөөллийг авч үзэх зайлшгүй шаардлагатай болдог. Хорих ял эдлүүлэх ажиллагааны сэтгэл судлал нь ялтны сэтгэцийн үйл ажиллагаа нь олон нийтээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал нөхцөлд ял эдэлж буй хүмүүсийн сэтгэл зүйн онцлог, өөрчлөлт, дасан зохицохуй, түгшүүр зэрэг олон талт сэтгэл зүйн үйл ажиллагааг судлахаас гадна тэдэнд нөлөөлж буй хүчин зүйлс /эерэг, сөрөг/ сэтгэл санааны янз бүрийн байдлыг бий болгодог үйл ажиллагааг харгалзан судалдаг.

ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газраас гаргасан статистик тоон мэдээнээс үзвэл хорих байгууллагад ялтны зүгээс 2009 онд 1030 зорчил, 2010 онд, 1101 зорчил, 2011 онд 1795 зорчил, 2012 онд, 1956 зорчил, 2013 онд 2082 хорих ангийн дотоод журам зорчсон зорчлийг тус тус үйлдэжээ.⁶⁶

Дээрх судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд хорих ял эдлүүлэх ажиллагаанд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоо тогтмол байдлаар нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь хорих байгууллагын ажилтны болон ялтны сэтгэл зүйн орчин, хувь хүний өвөрмөц онцлог шалтгаан, нөхцлийг сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс судлах, харьцуулан дүгнэх шаардлага зүй ёсоор бий болж байна.

Хэдийгээр ялтан гэдэг ойлголт нь ял шийтгэл эдэлж байгаа янз бүрийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн орчин хүрээг хамарч байдаг хэдий

⁶⁶ Тогтоол гүйцэтгэх газрын 2013 оны нэгдсэн тайлан

ч нөгөөтэйгүүр нэг ижил гэмт хэргийн цаана хууль зүйн ангиллын үүднээс авч үзэхэд криминал нөлөөлөл болон хувийн чанараар янз бүрийн түвшний хүмүүсийг хамааруулан ойлгож болно.

Тэгэхээр ялтны сэтгэл зүйн онцлогийг “Хүн” гэх талаас нь тайлбарлахад хүмүүст байдаг бүхий л шинж чанар нь тухайн хүнд илэрдэг, эс илэрдэгээс хамаарахгүйгээр цогц байдлаар тусгадаг. Харин “Хувь хүн” гэх ойлголт нь зөвхөн тухайн хүний хувьд илэрч гардаг шинж чанаруудыг илэрхийлэхийн хамтаар бодгаль, биологийн ба сэтгэл зүйн шинж онцлогийг өөртөө агуулдаг ойлголт юм. Үүнээс гадна “Хувийн өвөрмөц онцлог” гэдэг нь хамгийн явцуу хүрээг хамарсан, илүү тодорхой ойлголт байдаг, энэ нь хувь хүн, бие хүн, субъектийн шинж чанар, тэдгээрийн хослолын дундаас тухайн нэг хүний сэтгэцийн хөгжлийг бусдаас ялгаруулан онцгойруулж байгаа тэр хэсгийг хамааруулан ойлгож болно гэж тодорхойлсон байдаг.

Гэтэл “Бие хүн (Person)”⁶⁷ гэдэг нь угтаа сэтгэл судлалын ухагдахуун биш, харин хүний асуудлыг судалдаг тусгай шинжлэх ухаанд хэрэглэгддэг ойлголт юм. Бие хүн өөрөө “бие сэтгэцийн цогц” шинжтэй, өөрөөр хэлбэл түүний үндсэн чиг үүрэг, шинж чанарууд нь ч мөн ийм байдаг. Бие хүн бол нийгмийн доторх хүн, түүхт процессын объект, субъект нь юм. Өөрөөр хэлбэл тухайн нийгэмд амьдарч нийгмийн харилцаа болон материаллаг үйлдвэрлэлд идэвхтэй оролцогч, тодорхой түүхт хүнийг “бие хүн” гэж тодорхойлсон байдаг нь нийгмийн хүрээний хамгийн бага бүрдэл нэгж гэж ойлгож болно.

“Хүн”-ий зүгээс эргэн тойронд нь байгаа эд юмс, болж буй үзэгдэл, байгаль ертөнц, бусад хүмүүс, нийгэм зэрэгт хандах хандлага, тэдний практик үйл ажиллагааны үйл явц, үр дүнг дотоод сэтгэлдээ шууд тусгаж мэдрэх хэлбэрээр илэрч гардаг сэтгэцийн онцгой төрлийн хийсвэрлэл, сэтгэлийн хөдөлгөөн гэж тодорхойлдог.

Сэтгэлийн хөдөлгөөний хэлбэрүүд нь “Хүн”-д сэтгэл санааны байдал, мэдрэмж, уур уцаар, хүсэл тачаал, хямрал түгшүүр гэхчилэн олон янзаар илэрдэг.⁶⁸ Өөрөөр хэлбэл хүний хийж үйлдэж, танин мэдэж байгаа, мөн түүнийг хүрээлэн буй бүх зүйлд хандаж буй хандлагад хүний хэрэгцээнд нийцэх, үл нийцэхээс /эерэг, сөрөг/ шалтгаалан хүнд бий болж буй бодис юмс үзэгдэлд хандах онцгой хэлбэрийн илрэлийг “сэтгэл хөдлөл” сэтгэлийн хөдөлгөөн гэж тодорхойлон ойлгож болно.

Сэтгэл хөдлөл нь бодьгалийн үйл ажиллагааг зохион байгуулах, дотроос нь өдөөж түлхэц өгөх, чиглүүлэх гэхчлэн олон төрлийн чиг үүргийг нэг дор гүйцэтгэдэг ихээхэн бүхэллэг, цогц шинжтэй сэтгэцийн үзэгдэл юм. Маш их аюултай, хямрал зөрчилтэй нөхцөл байдалд субъект /хүн/ түргэн хугацаанд сэтгэл зүйн талаас ухаалаг гарц олж харж чадахгүй тохиолдолд

67 Тогтоол гүйцэтгэх газрын 2013 оны нэгдсэн тайлан

68 Д.Доржжигиев Сэтгэл зүйд өөрөө сурилгах нь. УБ., 2005., 560-р тал

сэтгэл хөдлөлийн онцгой төрөл болох цухалдал үүсч хуримтлагдана. Сэтгэл цухалдлын нэг тодорхой илрэл нь бие хүний эволюцийн хөгжлийн явцад бий болсон, субъектийн зүгээс нөхцөл байдлыг шийдэх тодорхой арга болох /зугтах, хөшиж зогсох, хэрцгий авирлах гэх зэрэг/ “аюулын гарц” болдог. Үүнийг ОХУ-ын эрдэмтэн П.К.Анохин сэтгэл хөдлөл нь дайчлах ба нэгдсэн хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байдаг хэмээн судлан тодорхойлсон байдаг.⁶⁹

Олон нийтийн зан үйлийн талаарх нийгмийн чиг хандлага нь нэг дор бөөн хүн /бөөгнөрөл, масс/ цугласан нөхцөлд тэдний зан үйл, хариу үйлдлийн байдалд мэдэгдэхүйц хүчтэй нөлөөлөл үзүүлж эхэлдэг онцлогтой. Энэ нь ямар нэг зүйлд сэтгэл ханамжгүй байгаа олон хүн “гал дүрэлзэх” маягаар хандаж хуйлрах нь элбэг байдаг, түүний дараа тэдний зан үйл ердийн хэвийн зохицуулалтаа алдаж, түрэмгий, эвдэн сүйтгэх, яахаас ч буцахгүй байдалд шилждэг нь хүмүүс олон нийтийн талаарх бодит төсөөлөл юм.

Өнөөгийн чиг хандлагаар хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах, нийтийг хамарсан өлсгөлөн суулт зарлах, үймээн самуун дэгдэх зэрэг гэмт хэрэг, зөрчил гаргаж болзошгүй байгаа байдлыг сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс тайлбарлавал олон хүнийг хүчээр, түрэмгий /албадлага/-ын аргаар хяналтандаа байлгах санаархал нь нөхцөл байдлыг хүндрүүлэх, гарах гарцыг цөөрүүлдэг нь олон түмэн /бөөгнөрөл, масс/-ыг тэдэнтэй шудрага бус, хүчээр түрий барих байдлаар харьцаж, урьдын сэтгэл дундуур байсан зүйл “батлагдлаа” хэмээн үзсэн газруудад “гал дүрсхийх цэг” үүсдэг гэж тайлбарласан байдаг⁷⁰. Энэхүү дүгнэлтийг бусад судлаачид үймээн самууны асуудлыг судлах замаар давхар батласан байдаг. Өөрөөр хэлбэл бие махбодь сэтгэл хөдлөлийн үр ачаар гадны цочроолд хоромхон зуур асар их эрчтэй хариу үйлдэл үзүүлэх бөгөөд тухайн үеийн хариу үйлдлийн хэв шинж, хэлбэр болон бусад хэмжигдэхүүнүүдээр тодорхойлох боломж хомс байдаг.

Хэдийгээр бие хүний энэхүү үйл ажиллагааг тодорхойлох боломж хомс байдаг хэдий ч сэтгэл зүйн болон физиологийн нэгэн байдал болох “түгшүүр”⁷¹⁷² -ийн илрэл буюу эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдэл болох тайван бус байдал, айдас, зовнил зэрэгтэй хамааралтай таагүй мэдрэмжийг төрүүлдэг сэтгэл хөдлөлийн зүй тогтлоор нь авч үзэж тодорхойлж болох юм. Үүнийг онолын түвшинд /Психоаналитикийн онол/ 3 хэв шинжид тодорхойлон авч үздэг:

Бодит түгшүүр:- Гадны аюулыг ухааран ойлгохыг /гаднаас ирж

70 Назаретян, А.П., Психология стихийного массового поведения: Толпа, слухи. М., 2005


72 Фрейд З. Торможение, Симптом, Тревога / Freud S. Hemmung, Symptom und Angst, 1925
Хрестоматия по психологии и восприятию. М., 1975..

буй аюул занал, халдлага г.м/ бодит түгшүүр гэнэ. Энэ нь айж эмээхтэй ижил зүйл бөгөөд аюул заналын эх үүсвэртэй үр дүнтэй тэмцэх чадварыг бууруулж болзошгүй байдаг. Заналхийлэл зогсмогц бодит түгшүүр арилдаг. Ерөнхийд нь авч үзвэл бодит түгшүүр нь өөрийн аюулгүй байдлыг хангахад тус болдог.

Невротик түгшүүр:- Гадагш илэрхийлэн гаргах боломжтой хөөрөл, түлхэц ухамсарлагдсанаар болж тулгарах аюулын хариуд үүсч буй сэтгэцийн түгшүүрийг невротик түгшүүр гэнэ. Энэ тохиолдолд өөрийн мэдэлгүй ямар нэгэн аймшигт юм хийж түүнээс болж хүнд хор дагавар учрах бий гэж айснаас түгшүүр үүснэ.

Ёс суртахууны түгшүүр:- Супер эгогийн зүгээс үзүүлж байгаа заналхийлэлд эго арилсаны улмаас үүсч буй түгшүүрийг ёс суртахууны түгшүүр гэнэ. Ямарч ёс суртахуунгүй санаа бодол, үйлдлээ идэвхитэйгээр илэрхийлэхийг хүссэн хүслийн өөдөөс буруугаа мэдрэх, ичих, өөрийгөө буруутгах зэргээр илэрч байгаа тохиолдолд ёс суртахууны түгшүүр үүснэ. Суперэгогийн төгс шаардлагыг зөрчсөн ямар нэгэн үйлийнхээ төлөө /худлаа ярих, хууль бус үйлдэл буюу хулгай хийсхийхээ төлөө/ бусдаас авах бодит шийтгэлээс ёс суртахууны түгшүүр үүсдэг. Энэ нь цаашлаад нийгмийн түгшүүрийг бий болгодог. Нийгмийн түгшүүр нь бусад хүмүүс хүлээн авах боломжгүй чиг хандлага, үйлдлээсээ болж тухайн хүрээллээс хасагдах аюултай холбоотой юм. Өөрөөр хэлбэл хорих ангийн дэглэм, онцлогоос хамааран ялтан бие хүнд илрэх танин мэдэхүй, бие махбодь, сэтгэл хөдлөл, авир араншингийн харилцан адилгүй онцлогоос шалтгаалан ямарваа нэг нөлөөлөлд тэдний зүгээс үзүүлэх хариу үйлдэл харилцан адилгүй байдаг.

Дээрх ангилалаас үзэхэд ялтны сэтгэл зүйн хямрал, гутралд оруулах цаашлаад гэмт хэрэг зөрчил үйлдэхэд хүргэж буй шалтгааныг түүний эх сурвалж, үүсч бий болгож буй нөхцөл, онцлог шинжийг харгалзан дараах байдлаар ангилж авч үзэж болно. Үүнд:



1. Хувийн зан байдал, сэтгэл зүйн онцлогтой холбогдсон шалтгаан:

1.1 Төрөлхийн болон олдмол сэтгэл зүйн онцлог, өөрчлөлт.

Хэдийгээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад болон шүүхийн шатанд хэрэг хариуцах чадвартай эсэх нь тогтоогдсон хэдий ч хорих ял эдлэх явцад илт сэтгэцийн өөрчлөлтөнд орох, урьдын элдэв эмгэг сэдэрх байдлаар ноцтой хор уршиг бүхий үйлдэл гэмт хэрэг, зөрчлийг ялгнуудын зүгээс үйлдэх явдал практикт олонтоо тохиолддог. Иймд хорих ял эдлэх үед ялтны сэтгэцийн байдлыг нарийвчлан шалгах буюу нарийн мэргэжлийн эмнэлгийн шинжилгээ явуулах талаар тодорхой зохицуулалт шаардлагатай болдог бөгөөд энэ талаар одоогоор нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

1.2 Тухайн хоригдогчийн хувийн өвөрмөц зан байдал, онцлог. Тухайлбал:

- өөртөө итгэлгүй, амьдралын тодорхой зорилгогүй байдал
- өөрийгөө буруутгах, жигших үзэл бодол
- гутранги үзэлд байнга буюу хэт автах
- хэт айдаст автсан эсхүл байнгын уур цухалтай байх
- ямар нэгэн зүйлд байнга санаа зовинох, түгшүүртэй байх

Эдгээр хувийн зан байдлын онцлог нь сэтгэл зүйн хувьд хямралд орох шалтгаан болохоос гадна хоригдогсдын зүгээс өөр бусад ноцтой гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ч зайлшгүй нөлөөлдөг гэдгийг үгүйсгэх аргагүй юм.

1.3 Дасан зохицох чадваргүй байдал.

Энэ нь тухайн ялтан бие даан тодорхой харилцаанд оролцох чадваргүй байдлаасаа хамаарч орчны өөрчлөлтийг хүлээн авч түүнд дасан зохицохгүй байдлаар илэрхийн зэрэгцээ сэтгэл зүйн гүнзгий хямралд хүргэх нэг шалтгаан болдог. Тухайлбал хорих ангийн онцлог, дотоод зохион байгуулалт, дотоод журам, түүнчлэн хамт ял эдлэгсдийн харьцаа, хандлага зэргийг өөртөө хүлээн авахад үүсдэг.

1.4 Согтуурах, мансуурах дон.

Согтуурах, мансуурах дон, сэтгэл зүйн ачаалал, түүнээс үүдсэн дарамттай байх нь зарим тохиолдолд амиа хорлох болон бусад гэмт хэрэг зөрчлийн сэдэл төрөхөд онцгой нөлөөлдөг гэж үзэж болно.

1.5 Өөрийн үйлдсэн хэргээс жигших, түүндээ гутрах

Дээрхи шалтгаан буюу аливаа сэтгэл зүйн болон хувийн онцлог зан байдлууд нь сэтгэлзүйн хямралд орох шалтгаан болохын зэрэгцээ ихэнхи тохиолдолд бусад шалтгаан нөхцөлтэй хавсран сэтгэл зүйн тэнцвэрт байдлаа алдах шалтгаан болдог.

2. Гэр бүлийн харилцаатай холбогдсон шалтгаан.

Гэр бүлийн харилцаатай холбогдсон шалтгаан нь цөөнгүй тохиолдолд нийгмээс тусгаарлагдан хуулийн дагуу тодорхой хязгаарлалтанд байгаа ял эдлэгсдийн сэтгэл санааны өөрчлөлтөнд нөлөөлөх томоохон шалтгаан болдог. Үүнд:

2.1 Гэр бүлийн гишүүдийн амьдралын таагүй нөхцөл. Өөрөөр хэлбэл ямар нэг орлогогүй, амьжиргааны эх үүсвэргүй, ядуу зүдүү амьдрал, тодорхой орон байргүй байдал нь тухайн хоригдогчид сэтгэл зүйн маш их дарамт болохын хажуугаар үүнд өөрийгөө буруутгаж, сэтгэл санааны хямралд оруулдаг.

2.2 Гэр бүлийн гишүүн буюу дотны хүн нас барах (эсхүл хүнд өвчлөх). Хорих ял эдэлж байх хугацаанд гэр бүлийн гишүүн буюу хамгийн их хайрлаж, хүндэлж явсан хүний нас баралт нь мөн ялтны сэтгэл санаанд хүчтэй нөлөөлөх шалтгааны нэг гэж тодорхойлж болно.

2.3 Гэр бүлийн зөрчил. Үүнд гэр бүл салалт, гэр бүлийн гишүүдтэй маргах, үл ойлголцох, үл итгэх байдал зэргийг оруулан ойлгож болно.

2.4 Гэр бүлийн харилцаатай холбогдсон бусад гэнэтийн өөрчлөлтүүд.

3. Орчны өөрчлөлт буюу гаднах орчны нөлөөлөл.

3.1 Хорих ангийн онцлог зохион байгуулалт.

Шүүхийн шийтгэх тогтоолоор заагдсан төрөл, дэглэмийн онцлог орчинд ч аливаа ялтны дасан зохицоход тодорхой бэршээлүүд гардаг. Түүнчлэн хорих ангийн байршлын онцлог, үйлдвэрлэлийн чиглэл, хөдөлмөрлөх үйл ажиллагаанд хамрагдаж байгаа ялтныг энэхүү онцлогт дасан зохицоход ч зайлшгүй анхаарах шаардлагатай.

3.2 Хоригдогсдын дунд нэр хүндгүй болох, ичгүүртэй байдалд орох. -Үйлдсэн хэргийн улмаас нэр хүндгүй болох, гадуурхагдах, Тухайлбал.

Хүчингийн гэмт хэрэг үйлдсэн, тэр тусмаа бага насны хүүхэд хүчирхийлсэн этгээд нь ялтан хоригдогсдын дунд нэр хүндгүй байхын зэрэгцээ илт гадуурхах хандлага байдаг.

- Бэлгийн чиг хандлага Манай өнөөгийн нийгэмд, үндэсний сэтгэл зүйн онцлогоос шалтгаалан төдийлөн бэлгийн чиг хадлага буюу ижил хүйстнийг нийгмийн аль ч давхаргад хүлээж авдаггүйн зэрэгцээ жигших, гадуурхах явдал байдаг. Энэ хандлагыг тухайн хоригдогч хүндээр тусгаж авдаг.

3.3 Хамт хоригдогсод болон ял эдлэгсдийн зүгээс үзүүлж буй дарамт шахалт:

Энэ нь ялангуяа удаа дараа ял эдэлж байсан болон удаан хугацаагаар цагдан хоригдсон хоригдогсдоос байнгын шинжтэй үйлдэгддэг.

3.4 Албаны болон албан хаагчийн харилцаа.

Зарим тохиолдолд албан хаагчийн зүй бус харьцаа, бусад үйлдлийн улмаас хоригдогч, ялтан сэтгэл зүйн хувьд хямрах явдал байдаг. /Гэхдээ энд албан хаагчийг зориуд хууль зүйн хариуцлагад холбогдуулах, ямар нэг байдлаар хохирол учруулах зорилгоор хуурамчаар тухайн албан хаагчийг өөрийн үйлдлийн буруутан болгох санаа агуулсан үйлдэл цөөн бус үйлдэгдэл байдаг гэдгийг тооцон үзэх шаардлагатай./

1971онд Станфорд их сургуульд Сэтгэл судлаач профессор Филлип Зимбардо-ын удирдлаган доор явагдсан туршилт судалгааны дүнгээс бодит байдалд тайлбар огах болов уу гэж үзэж байна. Уг туршилтаас үзэхэд бие хүн нь, нийгэм дэх олон олон "статус" дүр төрх дотор бүсдэнэ хүлээгдэж байгаа "статус" дүр төрх болон өөрөө өөртөө оноож байгаа "статус" дүр төрхдөө өгөгдсөн эрх мэдэл, "илмдэж", нөхцөл байдалд өөрийн мэдэлтэй болон мэдэлгүйгээр тааруулан "жүжиглэж", улмаар түүндээ шингэн ордог гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл нөхцөл байдал, эрх мэдэл, боломж нь бүрдсэн бөл ямар ч хүн хэрцгийг авирлан хүчирхийлж, дарангуйлах, зүй бус үйлдэл хийх магадлалтай юм.

Иймд хорих ангийн дэглэм, онцлогтой уялдуулан ялтныг сэтгэл зүйн хувьд тодорхойлох, тэдний зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлахын тулд бие хүнд илрэх танин мэдэхүй, бие махбодь, сэтгэл хөдлөл, авир араншингийн бүрэлдэхүүн хэсгүүдээр тодорхойлогдох онцлог үйл ажиллагааг бие хүний хувьд судлан тодорхойлох, бусад ямарваа нэг нөлөөллийн үйлчлэлээр үзүүлэх хариу үйлдлийн түвшин, цар хүрээг тодорхойлох хэмжүүрийг бий болгох. юм.

Иймд хорих ял эдлүүлэх ажиллагаанд ялтны сэтгэл зүйн байдлыг гэмт хэрэг зөрчилтэй холбон урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд "ялтан" бие хүний сэтгэл зүйн байдлыг тодорхойлох, зөвхөн нийгмийн тал буюу тогтсон хандлагыг судлахаас гадна, мон физиологийн/биесэтгэцийн/илрэлийг тодорхой хүрээнд авч үзэндэлгэрүүлэн

судлах, харгалзан тусгах шаардлагатай гэж ойлгож болно. Тухайлбал онц аюултай гэмт хэрэгтэн бие хүн мөн санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдэж анх удаа ял эдэлж байгаа бие хүний хоорондын сэтгэл зүйн ялгаа асар их гэж төсөөлөгддөг хэдий ч албан ёсны тайлбар судалгааны дүнгээр баталгаажуулсан зүйл байдаггүй нь өнөөгийн төсөөлөл тогтсон хандлагыг бий болгоход хүргэж байна.

Дүгнэлт, санал:

- Ялтан нэг бүрийн “хувь хүний сэтгэл зүйн онцлог”-ийг онцлог үйл ажиллагааны хувьд судлан тодорхойлох, бусад ямарваа нэг нөлөөллийн үйлчлэлээр үзүүлэх хариу үйлдлийн түвшин, цар хүрээг тодорхойлох хэмжүүрийг бий болгох.

- Ялтны бүлэг /масс/-ын сэтгэл зүйн онцлог, өрнөлийг тогтмол судлаж дүн шинжилгээ хийх. Цаашид судалгааны ажлын үр дүнг хорих ял эдлүүлэх ажиллагаанд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн харилцан хамаарлыг судлах.

- Ялтны бүлэг /масс/-ын сэтгэл зүйн уур амьсгалд нөлөөлж болох гадны буюу мэдээлэл, нийгмийн нөлөөллийн талаарх хамаарлыг судлах.